



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/364

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай" А/114 дүгээр тушаал, энэ тушаалын хавсралтаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Дэд дарга (Нисэх буудлуудын үйлчилгээ хариуцсан)
Гишүүд:	Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын дарга Агаарын навигацийн, үйлчилгээний газрын дэд дарга Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны газрын Хуулийн хэлтсийн дарга Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга Холбоо, навигаци ажиглалтын албаны Үйлдвэрчний хорооны дарга
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн мэргэжилтэн

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг Зөвлөлд үүрэг болгосугай.

2.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай” А/44 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ